

**“БАРУУН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМААС МӨНХХАЙРХАН СУМ ЧИГЛЭЛИЙН 65
КМ АВТО ЗАМЫН ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨЛ /ХОВД” БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**

(НИЙТ ҮНЭД ҮНДЭСЛЭСЭН ГЭРЭЭ)

Улаанбаатар
2022 он



БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

Барилга, хот байгуулалтын
яамны Төрийн нарийн
бичгийн дарга

С.МАГНАЙСҮРЭН

Зам, тээврийн хөгжлийн
яамны Төрийн нарийн
бичгийн дарга

С.БАТБОЛД

ГҮЙЦЭТГЭГЧ:

УЛААНБААТАР ХОТ
“Гео зураглал” ХХК-ийн
захирал

Ж.БАТНАСАН

ТТА8138.5.5169712

**“БАРУУН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМААС МӨНХХАЙРХАН СУМ ЧИГЛЭЛИЙН 65
КМ АВТО ЗАМЫН ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨЛ /ХОВД/” БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**

2022 оны 05 сарын 12-ны өдөр

Дугаар № 2022/259 /179

Улаанбаатар хот

Нэг талаас Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээврийн хөгжлийн яам (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас “Гео зураглал” ХХК (цаашид “Зөвлөх” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2022 оны 05 сарын 12-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “Гэрээ” гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт №1-д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид “Үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь “Баруун босоо тэнхлэгийн авто замаас Мөнххайрхан сум чиглэлийн 65 км авто замын ТЭЗҮ, зураг төсөл /Ховд/” боловсруулах ажлыг (цаашид “Ажил” гэх) **391,400,240** (гурван зуун ерэн нэгэн сая дөрвөн зуун мянга хоёр зуун дөх) төгрөгөөр (цаашид “Гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв.
4. Гэрээний нийт дүн **391,400,240** (гурван зуун ерэн нэгэн сая дөрвөн зуун мянга хоёр зуун дөх) төгрөг. Үүнээс Барилга хот байгуулалтын сайдын 37-р тушаалын дагуу 2022 онд **220,500,000** (хоёр зуун хорин сая таван зуун мянга) төгрөг санхүүжих ба үлдэгдэл төлбөрийг тухайн жилд батлагдсан хөрөнгийн дүнгээр гүйцэтгэлийн дагуу олгоно.
5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
Гэрээний ерөнхий нөхцөл;
Гэрээний тусгай нөхцөл;
Хавсралт:
Хавсралт №1 Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ
Хавсралт №2 Тайлан гаргах хуваарь
Хавсралт №3 Ажиллах хүчин- Голлох мэргэжилтний ажлын хуваарь
Хавсралт №4 Төгрөгөөр тодорхойлсон төсөвт өртөг
Хавсралт №5 Тендерийн гүйцэтгэлийн баталгаа
6. Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
7. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

8. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.


ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Барилга, хот байгуулалтын
ямны Санхүү, хөрөнгө
оруулалтын газрын дарга

Зам, тээврийн хөгжлийн
ямны АЗБХЗГ-ын даргын
албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч

“Гео зураглал” ХХК-ийн
ерөнхий инженер



Э. ГАНХҮҮ
Э. ГАНХҮҮ

Б. ОЮУНДЭЛГЭР
Б. ОЮУНДЭЛГЭР

Г. НАМУУН
Г. НАМУУН

Барилга, хот байгуулалтын
ямны Санхүү, хөрөнгө
оруулалтын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн
дарга

Хянасан:
Зам, тээврийн хөгжлийн
ямны Хуулийн хэлтсийн
дарга

“Гео зураглал” ХХК-ийн
нягтлан бодогч

С. ДОЛЖИНСҮРЭН
С. ДОЛЖИНСҮРЭН

С. МЯНДАСМАА
С. МЯНДАСМАА

Д. МӨНХЗУЛ
Д. МӨНХЗУЛ

Барилга, хот байгуулалтын
ямны Төрийн захиргааны
удирдлагын газрын Хуулийн
хэлтсийн дарга

Зам, тээврийн хөгжлийн
ямны Хуулийн хэлтсийн
мэргэжилтэн

Б. НЯМДОРЖ
Б. НЯМДОРЖ

Д. ОЮУНСҮРЭН
Д. ОЮУНСҮРЭН

Зам, тээврийн хөгжлийн
ямны АЗБХЗГ-ын
мэргэжилтэн

О. ЛХАГВАСҮРЭН
О. ЛХАГВАСҮРЭН

Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүрэг, Барилгачдын талбай-
3, Засгийн газрын 12 дугаар
байр


Улаанбаатар хот,
Чингисийн өргөн чөлөө -11,
Засгийн газрын 13 дугаар
байр

Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 8-р хороо,
Залуучуудын өргөн чөлөө 13
дугаар байр, 6 тоот

Утас: +976 76003333
Факс: +976 0322904

Утас: +976 -(51)263185
Факс: +976-11312315

Байгууллагын регистер:
5169712
Утас: +976-11-313693;
+976- 88604450
Факс: +976-11-312897



II. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

1.1 Нэр томъёоны тайлбар

Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) “Гэрээнд хэрэглэх хууль” гэж Гэрээний тусгай нөхцөл ГТН-д заасан Монгол Улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актыг хэлнэ.
- (б) “Зөвлөх” гэж захиалагчтай байгуулсан энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлж байгаа аливаа хувийн болон төрийн хуулийн этгээдийг хэлнэ.
- (в) “Гэрээ” гэж талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт болон түүний 1 дүгээр заалтад дурдсан бусад баримт бичгүүд болох Гэрээний ерөнхий нөхцөл, Гэрээний тусгай нөхцөл болон хавсралт баримт бичгүүдийг хэлнэ.
- (г) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- (е) “Гэрээ хүчин төгөлдөр болох огноо” гэж ГЕН-ийн 2.1-д заасан гэрээ хүчин төгөлдөр болох огноог хэлнэ.
- (д) “Гэрээний үнэ” гэж ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу Үйлчилгээний гүйцэтгэлийн төлөө Зөвлөхөд төлөх төлбөрийн хэмжээг хэлнэ.
- (е) “ГЕН” гэж Гэрээний ерөнхий нөхцөлийг хэлнэ.
- (ё) “Гишүүн” гэж түншлэл /консорциум/ холбоог бүрдүүлж байгаа аль нэгэн хуулийн этгээдийг “Гишүүд” гэж эдгээр хуулийн этгээдийг хамтад нь хэлнэ.
- (ж) “Гэрээний тал гэж” Захиалагч эсхүл Зөвлөхийн аль нэгийг, харин “Талууд” гэж хоёуланг нь хэлнэ.
- (з) “Нөхөн төлөх зардал” гэж зөвлөхийн ажлын хөлснөөс бусад үйл ажилгаатай холбоотой бүх зардлуудыг хэлнэ.
- (л) “ГТН” гэж гэрээний ерөнхий нөхцөлийг тодотгож байгаа Гэрээний тусгай нөхцөлийг хэлнэ.
- (м) “Үйлчилгээ” гэж Хавсралт №1-т тодорхойлсон, энэхүү гэрээнд заасны дагуу Зөвлөхийн хийж гүйцэтгэвэл зохих ажлыг хэлнэ.
- (о) “Туслан гүйцэтгэгч” гэж үйлчилгээний аль нэгэн хэсгийг туслан гүйцэтгэхээр Зөвлөхтэй гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
- (ө) “Ажиллах хүчин” гэж Үйлчилгээ буюу түүний аль нэгэн хэсгийг гүйцэтгүүлэхээр Зөвлөхийн эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн хувь хүнийг хэлнэ.

1.2 Гэрээнд хэрэглэгдэх хууль


Энэхүү гэрээ, түүний агуулга болон тайлбар, мөн талуудын харилцааг ГТН-д заасан хууль тогтоомжоор зохицуулна.




- 1.3 Гэрээнд ашиглах хэл** Энэхүү гэрээ нь ГТН-д заасан улсын хэл дээр боловсруулагдсан бөгөөд гэрээний агуулга, тайлбартай холбоотой бүх асуудалд уг хэлийг ашиглана. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.
- 1.4 Мэдэгдэл** Энэхүү гэрээний дагуу олгогдсон эсхүл шаардагдах аливаа мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл зэргийг бичгээр үйлдсэн байх ёстой. Эдгээр мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл нь харилцаж байгаа талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид биечлэн хүргэгдсэн эсхүл ГТН-д заасан хаягаар илгээсэн тохиолдолд олгогдсон гэж тооцогдох ёстой.
- 1.5 Байршил** Үйлчилгээг, гэрээний хавсралт №1-т заасан нутаг дэвсгэрт, хэрэв тодорхой төсөл арга хэмжээний байрлалыг заагаагүй тохиолдолд захиалагчийн харъяа улс эсхүл түүний тодорхойлж өгсөн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ёстой.
- 1.6 Төлөөлөх эрх бүхий гишүүний эрх хэмжээ** Зөвлөх нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд, эдгээр гишүүд гэрээний дагуу захиалагчтай үүсэх харилцаанд бүх гишүүний нэрийн өмнөөс оролцох, эрх хэрэгжүүлэх болон үүрэг хүлээх, зааварчилгаа болон төлбөр хүлээн авахад тэднийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүнийг томилно.
- 1.7 Итгэмжлэгдсэн төлөөлөгч** Гэрээний дагуу захиалагч эсхүл зөвлөхийн гүйцэтгэвэл зохих аливаа үйл ажиллагаа болон баримт бичгийг ГТН-д заасан албан тушаалтан хариуцан хийнэ.
- 1.8 Татвар, хураамж** Зөвлөх, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажиллах хүчин нь ГТН-д заасан гэрээнд хэрэглэх хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой.
- 1.9 Авилгал болон залилан мэхлэх үйлдэл** Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч зөвлөх бүр худалдан авах ажиллагаанд оролцох, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.
- Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон зөвлөх нь Авилгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авилгал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ.

2. ГЭРЭЭ ЭХЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ЦУЦЛАХ

- 2.1 Гэрээ хүчин төгөлдөр болох** Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан, эсхүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээг хүчин төгөлдөр болох өдрийг гэрээ хүчин төгөлдөр болох огноо гэж хэлнэ.
- 2.2 Үйлчилгээг эхлэх** Зөвлөх нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстой.
- 2.3 Гэрээний хугацаа** ГТН-ийн 2.6-д заасны дагуу цуцлагдаагүй бол гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хугацааны дараагаар



	дуусгавар болох энэхүү гэрээний хугацаа дуусгавар болно.
2.4 Гэрээний өөрчлөлт буюу засвар	Гагцхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар хүрээг засварлах, эсхүл өөрчилж болно.
2.5 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл	2.5.1 Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол талууд тохиролцон гүйцэтгэх хугацааг сунгана. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Зөвлөх гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
2.6 Гэрээ цуцлах	
2.6.1 Захиалагч гэрээг цуцлах	Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй. (а) Зөвлөх гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй; (б) Зөвлөх (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа; (в) Зөвлөх нь тендерт оролцох буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгал, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа; (г) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон; (д) Захиалагч өөрийн санаачлагаар дээр зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол; (е) Зөвлөх ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрын ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй;
2.6.2 Зөвлөхийн санаачлагаар гэрээг цуцлах	Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд зөвлөх өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.



- (а) захиалагч нь ГЕН-ийн 7 дугаар зүйлд заасны дагуу ямар нэгэн маргаан үүсээгүй үед гэрээний дагуу төлбөл зохих аливаа төлбөрийг зөвлөхийн бичгээр гаргасан төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлөөгүй
- (б) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;
- (в) Захиалагч ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрийн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй;
- (г) Захиалагч гэрээний дагуу хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бөгөөд энэхүү зөрчлийн талаарх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 45 хоногийн хугацаанд (эсхүл зөвлөхийн бичгээр зөвшөөрөн сунгасан хоногт багтаан) тухайн зөрчлийг арилгаагүй;

2.6.2 Гэрээг цуцласан үед хийх төлбөр

ГЕН-ийн 2.9.1 болон 2.9.2 зүйлд заасны дагуу гэрээг цуцласан үед захиалагч дараах төлбөрийг зөвлөхөд төлөх ёстой:

- (а) Гэрээг цуцлах өдрөөс өмнө зохих ёсоор гүйцэтгэсэн бөгөөд ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу төлбөл зохих үйлчилгээний хөлс;
- (б) ГЕН-ийн 2.6.1-ийн (а)-гаас (в) хүртлэх, мөн (е) заалтын дагуу гэрээг цуцалснаас бусад тохиолдолд зөвлөхийн ажилтнууд, тэдний хууль ёсны хамтран амьдрагч нарыг буцаах замын зардал зэрэг гэрээг цуцалсны улмаас үүсэх аливаа бодит зардлын нөхөн олговор;

3. ЗӨВЛӨХИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1 Ерөнхий зүйл

3.1.1 Гүйцэтгэлийн чанар

Зөвлөх нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх ёстой бөгөөд тоног төхөөрөмж, машин механизм болон материалын хувьд аюулгүй, үр дүнтэй болон зүй зохист арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстой.


Зөвлөх нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч буюу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстой.

3.2 Ашиг сонирхлын зөрчил

Зөвлөх нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан захиалагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих ёстой бөгөөд өөр төсөл арга хэмжээ буюу өөрийн байгууллагын эрх ашигтай, сонирхолын зөрчилд орохоос зайлсхийх ёстой.

3.3 Нууцлал

Зөвлөх, түүний ажилтнууд нь захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гэрээний хэрэгжилтийн явцад олж авсан




аливаа нууц мэдээллийг ямар нэгэн хувь хүн, байгууллагад дамжуулах эрхгүй бөгөөд үйлчилгээний үр дүнд боловсруулсан зөвлөмжийг нийтэд нээлттэй болгох эрхгүй

- 3.4 Зөвлөхийн хариуцах даатгал** Зөвлөх нь захиалагчийн зөвшөөрсөн нөхцөл, болзолын дагуу болон ГТН-д тусгайлан заасан эрсдэлд хамаарах даатгалыг өөрийн зардлаар хариуцан хийлгэх бөгөөд даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагчид ирүүлнэ.
- 3.5 Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авбал зохих үйл ажиллагаа** Зөвлөх нь дор дурдсан үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстой. Үүнд:
- (а) Үйлчилгээний аль нэг хэсгийн гүйцэтгэлийг туслан гүйцэтгэх гэрээгээр хийлгэх,
 - (б) Хавсралт №1-т заасан ажилтны жагсаалтанд ямар нэг өөрчлөлт, нэмэлт оруулах.
 - (в) ГТН-д тусгайлан заасан бусад үйл ажиллагаа
- 3.6 Тайлагнах хуваарь** Зөвлөх нь Хавсралт №2 -т заасан тайлан болон баримт бичгийг тухайн хавсралтад заасан маягтын дагуу тогтоосон хугацааны дотор хүргүүлэх ёстой.
- 3.7 Зөвлөхийн боловсруулсан баримт бичиг захиалагчийн өмч болох нь** Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлахаас өмнө эдгээр материалыг дэлгэрэнгүй жагсаалтын хамтаар захиалагчид хүргүүлнэ. Зөвлөх нь эдгээр бичиг баримт болон программ хангамжийн хувийг авч болно.
- 3.8 Нягтлан бодох бүртгэл, Хяналт шалгалт болон Аудит** Зөвлөх нь гэрээний гүйцэтгэлд хамаарах нягтлан бодох данс, бүртгэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хөтлөн явуулах бөгөөд захиалагч түүний томилсон төлөөлөгч эсхүл аудитор эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийх эрхтэй.

4. ЗӨВЛӨХИЙН АЖИЛТНУУД

- 4.1 Ажиллах хүчний тодорхойлолт** Зөвлөхийн санал болгож буй гол мэргэжилтэн бүрийн албан тушаал, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн түвшин болон үйлчилгээг гүйцэтгэхэд оролцох хугацаа зэргийн талаарх мэдээллийг Хавсралт №3-т тусгана. Захиалагчтай урьдчилан тохиролцсон гол мэргэжилтний мэдээллийг мөн хавсралтанд багтаана.
- 4.2 Ажилтныг халах буюу солих**
- (а) Захиалагч зөвшөөрөөгүй бол ажиллах хүчний бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт хийх ёсгүй. Зөвлөхийн эрх хэмжээнээс үл хамаарах, тухайлбал, тэтгэвэрт гарах, нас барах, эрүүл мэндийн хувьд чадваргүй болох, бусад шалтгааны улмаас ажилтныг солих зайлшгүй шаардлага гарвал түүнтэй тэнцүү буюу илүү чадвартай хүнээр солих асуудлыг цаг алдалгүй тавина.
 - (б) Аль нэгэн ажилтан үүргээ ноцтой зөрчсөн буюу гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үүргийн гүйцэтгэл хангалтгүй байгаа талаар хангалттай үндэслэл захиалагчид байгаа тохиолдолд



захиалагчаас бичгээр гаргасан үндэслэл бүхий шаардлагын дагуу түүний хүлээн зөвшөөрөхүйц чадвар болон туршлага бүхий ажилтнаар солих ёстой.


- (в) Ажилтныг халах, эсхүл солихтой холбоотой үүсч болох ямар нэгэн нэмэлт зардлыг зөвлөх нэхэмжлэх эрхгүй болно.

5. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 5.1 Дэмжлэг үзүүлэх болон зөвшөөрөл олгох** Захиалагч нь ГТН-д заасан зөвлөхөд үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон холбогдох зөвшөөрлийг засгийн газрын зүгээс олгуулахын тулд бүх талын хүчин чармайлт гаргана.
- 5.2 Гэрээнд хэрэглэх хуулинд татвар хураамжийн талаар орсон өөрчлөлт** Хэрэв, гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуулинд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Зөвлөхийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа бол, талууд тохиролцон гэрээний дагуу Зөвлөхөд төлөх цалин болон нөхөн төлөгдөх зардлын хэмжээг өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга нь ГЕН-ийн 6.2 (а), (б), -д заасан төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстой.

6. ЗӨВЛӨХӨД ТӨЛӨХ ТӨЛБӨР

- 6.1 Нийт төлбөр** Зөвлөхөд төлөх нийт төлбөрийн хэмжээ нь гэрээний хавсралт №1-т тодорхойлсон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүх зардлыг тооцсон тогтмол нийт үнийг багтаасан гэрээний үнээс хэтрэх ёсгүй. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу өөрчлөснөөс бусад тохиолдолд ГЕН-ийн 6.2-т тодорхойлсон үнийн хэмжээг гагцхүү ГЕН-ийн 2.4-т зааснаар талууд нэмэлт төлбөр хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нэмэгдүүлж болно.
- 6.2 Гэрээний үнэ** (а) Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.
(б) Төгрөгөөр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.
- 6.3 Нэмэлт үйлчилгээний төлбөр** ГЕН-ийн 2.4-т заасны дагуу төлөхөөр зөвшөөрч болох нэмэлт үйлчилгээний цалингийн хэмжээг тодорхойлохын тулд нийт үнийн задаргааг Хавсралт №4 болон №5-д оруулна.
- 6.4 Төлбөр хийх нөхцөл. хуваарь** Төлбөрийг ГТН-д заасан төлбөр хийх хуваарийн дагуу, тэнд заасан зөвлөхийн дансанд хийнэ. ГТН-д өөрөөр заагаагүй бол, түүнд тогтоосон хугацаанд хүчинтэй байхаар тооцож, зөвлөхийн ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнтэй тэнцэх хэмжээгээр эхний төлбөрийг хийнэ. Энэхүү баталгааг Хавсралт №7-д заасан маягт, эсхүл захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрсөн өөр маягтаар гарган ирүүлнэ.
- ГТН-д заасан нөхцөл болзолыг хангасны дараа, зөвлөхөд төлбөл зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон нэхэмжлэлийг захиалагчид ирүүлснээр бусад төлбөр хийгдэх ёстой.
- 6.5 Хугацаа** Захиалагч нь ГТН-ийн 6.4-д тогтоосон төлбөр хийх хугацааг арван



**хоцорсон
төлбөрийн
хүү**

таван хоногоос (15) дээш хоногоор хэтрүүлсэн бол хугацаа хоцорсон хоног тутам ГТН-д тогтоосон хэмжээгээр зөвлөхөд хүү төлөх ёстой.

7. ШУДАРГА БАЙДАЛ

7.1 Шударга байдал

Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биенийхээ эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгыг хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна.


8. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

8.1 Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх


Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтанд ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө. Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

8.2 Маргааныг шийдвэрлэх


Талууд гэрээний холбоотой аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд аль нэг тал нь ГТН-д заасан маргааныг шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох эрхтэй.



ГЕН-ийн зүйлийн дугаар	III. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ
{1.1(а)}	Гэрээнд хэрэглэх хууль нь { Монгол Улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актууд}
1.3	Гэрээний баримт бичгүүд нь Монгол хэл дээр байна.
1.4	Захиалагч: Барилга, хот байгуулалтын яам Захиалагчийн хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3, Засгийн газрын 12 дугаар байр. Харилцах хүн: Барилга, хот байгуулалтын яамны Хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн Ж.Орхонбаяр Утас: 99017228 Захиалагчийн хяналт гүйцэтгэгч: Зам, тээврийн хөгжлийн яам Харилцах хүн: ЗТХЯ-ны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Оюундэлгэр Утас: 26-31-85 Зөвлөх: “Гео зураглал” ХХК Зөвлөхийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 13 дугаар байр, 6 тоот Харилцах хүн: Захирал Ж.Батнасан Утас: 88604450, 11-313693 И-мэйл: geozuraglal@gmail.com Факс: 976-11-312897
1.7	Итгэмжлэгдсэн төлөөлөгчид: Захиалагчийн: ЗТХЯ-ны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн О.Лхагвасүрэн Утас: 26-71-85, 99903047 Зөвлөхийн: “Гео зураглал” ХХК-ийн захирал Ж.Батнасан Утас: 88604450, 11-313693
1.8	Татвар: Зөвлөх нь ажлыг гүйцэтгэхтэй холбогдон төлөгдөх бүх татвар, хураамж, шимтгэлийг төлөх асуудлыг өөрсдөө хариуцна. Зөвлөхийн ирүүлэх үнийн саналд хуулийн дагуу төлөх татвар, даатгал, хураамж, багтсан байна.



2.2	Тогтоосон хугацаа: Гэрээ байгуулсан өдрөөс эхэлнэ.
2.3	Тогтоосон хугацаа: Гэрээ байгуулсанаас хойш 180 хоног
{3.5 (в)}	Бусад үйл ажиллагаа: Захиалагч нь ТЭЗҮ, зураг төслийг холбогдох байгууллагуудтай зөвшилцөх, техникийн нөхцөл гаргуулах, магадлалаар хянуулах зэрэг ажилд зөвлөхөд дэмжлэг, туслалцаа үзүүлж холбогдох зөвшөөрлийг олгуулахад дэмжлэг үзүүлнэ.
	Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: 391,400,240 (гурван зуун ерэн нэгэн сая дөрвөн зуун мянга хоёр зуун дөч) төгрөг
6.4	Төлбөр хийх данснууд: Голомт банк, 1601375103 Төгрөгийн хувьд: 391,400,240 (гурван зуун ерэн нэгэн сая дөрвөн зуун мянга хоёр зуун дөч) төгрөг Төлбөрийг дараахь хуваарийн дагуу төлнө. Тэмдэглэл: (а) дор дурдсан төлбөрийн хуваарь нь зөвхөн дүн шинжилгээ хийх, жишээ болох зорилготой; (б) гадаад мөнгөн тэмдэгт болон төгрөгөөр хийх хуваарь харилцан адилгүй бол салангид хуваарь гаргаж мөрдөнө. а) Эхлэлийн тайлан, геодезийн тайланг захиалагчид хүлээлгэн өгснөөс хойш 14 хоногт багтаан гэрээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх дүнг төлнө. б) Дунд шатны тайлан, инженер геологийн тайланг захиалагчид хүлээлгэн өгснөөс хойш 14 хоногийн дотор гэрээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх дүнг төлнө. с) ТЭЗҮ-г батлуулж, инженерийн нарийвчилсан зураг төслийг Магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулж, хүлээлгэж өгснөөс хойш 14 хоногт багтаан гэрээний үнийн дүнгийн 35 хувьтай тэнцэх дүнг төлнө. д) Гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх барьцааг авч үлдэх ба барилгын улаан шугам хүлээлцэх үед зураг төслөөс шалтгаалсан доголдол үүсээгүйг барилгын гүйцэтгэгч хүлээн зөвшөөрсөн, эсхүл барилгын ажил эхлэлгүй 2 жил өнгөрсөн тохиолдолд гэрээ дүгнэсэн актыг үндэслэн чөлөөлнө. е) Нарийвчилсан зураг төслийг эх хувь-1, хуулбар хувь-1, CD-2 /autocad, pdf/ хувийг хүлээлгэж өгнө.
6.5	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0.05 хувь байна. Нийт гэрээний үнийн 10%-иас хэтрүүлэхгүй.
8.2	Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.




Хавсралт №1 Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ



БАРУУН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМААС ХОВД АЙМГИЙН МӨНХХАЙРХАН СУМ ЧИГЛЭЛИЙН 65 КМ АВТО ЗАМЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 09 сарын 09-ны өдөр	№17/22	Улаанбаатар хот
1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 2-р хавсралт, БХБСайдын 2021 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 10 дугаар тушаал	
2. Байршил	Ховд аймгийн Манхан, Мөнххайрхан сумдын нутаг дэвсгэрт	
3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Улсын төсөв	
4. Замын техникийн ангилал, замын зэрэг	Хуримтлуулагч зам (Хөдөлгөөний 2 зурвастай, зорчих хэсэг нь зааглагдаагүй, тооцоот хурд нь 80 км/цаг)	
5. Замын эхлэлийн цэг	Баруун босоо тэнхлэгийн авто замаас салаална.	
6. Ойролцоо өнгөрөх төв, суурин газар ба дайрах цэг		
7. Замын төгсгөлийн цэг	Ховд аймгийн Мөнххайрхан сумын төв	
8. Замын хучилтын хийц	Асфальтобетон хучлага, хөрсийг цементээр бэхжүүлсэн суурь бүхий хучилтын хийцийг зургийн ерөнхий инженерийн техникийн шийдэл ба тооцоогоор сонгоно.	
9. Төлөвлөлтийн норм	• "Авто зам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016 • "Хот тосгоны төлөвлөлт ба барилгажилт" БНБД 30-01-04 • "Хот суурины гудамж зам төлөвлөлт" БНБД 32-01-04 • "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" АЗУАГН 2.01.01-2004 • "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" БНБД 22.01.01*/2006 • "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНБД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил" БНБД 3.01.03-88	




- "Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" MNS4597:2014
- "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" MNS4596:2014
- "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль /БД 31-101-04/ барилгын дүрэм
- "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056:2009
- Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598: 2011

10. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа

Нэг үе шаттай, 2022 оны 3 дугаар улиралд багтаан гүйцэтгэнэ.

11. Зураг төслийн иж бүрдэл

- "Геодези зураг зүйн тухай" хуулийн 6.1.3 дугаар заалт, "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНБД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил" БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу байр зүйн хэмжилтийн ажлын тайлан
- Буурь хөрс болон зам барилгын ажилд хэрэглэх түгээмэл тархацтай (чулуу, далан, суурийн хайрга, хөрс гэх мэт) материалын тойм судалгааг багтаасан Инженер-геологийн хайгуул судалгааны ажлын тайлан
- Дараах хэсгүүдийг нэгтгэсэн Авто замын ажлын иж бүрэн зураг төсөл:
 - Авто зам, хиймэл байгууламж, гүүрийн ажлын иж бүрэн нарийвчилсан зураг төсөл;
 - Зам, замын байгууламжийн барилгын ажлын техникийн шаардлага;
 - Зам, гүүрийн зурваст орсон инженерийн байгууламж, цахилгаан, холбооны шугам сүлжээний техникийн нөхцөлийг холбогдох байгууллагуудаас авах, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, засварлах, өндөрсгөх ажлын тоо хэмжээ, зардал;
 - Ажилбар тус бүрийн болон Барилгын ажлын нэгдсэн тоо хэмжээ;
 - Инженерийн дэлгэрэнгүй тайлан (ИДТ);



- Зам барилгын ажилтай холбоотой газар олгосон орон нутгийн засаг захиргааны захирамж болон бусад зөвшөөрөл, техникийн нөхцөлүүд;
- Том оврын тээврийн хэрэгслийн зогсоолын талбайн зураг төсөл;
- Зураг төслийн иж бүрдэл тус бүрийг баталгаажуулсан Магадлалын ерөнхий дүгнэлт

12. Зураг төслийн байгууллага

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу шалгарсан хуулийн этгээд

13. Захиалагч байгууллага

Зам, тээврийн хөгжлийн яам

14. Онцгой нөхцөл

- Төлөвлөж буй авто замын трассыг хувилбаруудын харьцуулалтаар сонгон тогтоож, тухайн орон нутгийн удирдлагатай зөвшилцөж санал авах, Захиалагчид танилцуулах, шаардлагатай тохиолдолд салбарын Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;
- Ойролцоо өнгөрөх сумын төвүүдийг гол замтай холбосон холбоос замыг төсөллөх;
- Уулзвар гарцыг төсөллөхдөө хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг сайтар харгалзах;
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд төсөллөх, Тээврийн цагдаагийн албанаас санал авах;
- Ухмал ба зам дээр цас хунгарлахаас сэргийлэх далангийн шийдлийг төсөллөх;
- Халиа тошин, үер, уруйгаас хамгаалах байгууламжийг төсөллөх;
- Замын дагууд замын үйлчилгээний байгууламжийг төлөвлөх боломжтой газруудыг судалж, ИДТ-д тусгах;
- Замын шаардлагатай хэсэгт холбогдох норм дүрмийн дагуу амрах талбай, түр зогсоол төсөллөх;
- Газар хөдлөлтөөс үзүүлэх нөлөөллийг тооцох;
- Авто замын чиглэлийг сонгохдоо цас мөсний үйлчлэл, үс дулааны горим, гадаргуун ус зайлуулалт гэх мэтчилэн байгаль цаг уурын хүчин зүйлсийн

үйлчлэлийг судлах, тухайн байршил цэвдэгтэй бүс нутагт хамрагдаж байгаа тул нарийвчилсан судалгаа хийлгэж, түүний үр дүнг үндэслэн далангийн хийцийг төсөллөх;

- Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөлд тусгах;
- Зургийн байгууллага хариуцлагын даатгалд хамрагдсан байх;
- Инженерийн нарийвчилсан зураг төслийн иж бүрдлийг Захиалагчаар хянуулж, зөвшилцсөний дараа Магадлалд оруулна.

Хянасан:

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч



Б.ОЮУНДЭЛГЭР

Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга



Ё.ЖАРГАЛСАЙХАН

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга




Ч.ЖАРГАЛСАЙХАН

Боловсруулсан:

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч




М.УГТАХБАЯР



Хавсралт №2 Тайлан гаргах хуваарь

№	Тайлан	Тайлан гаргах хугацаа
1	Эхлэлийн тайлан	Гэрээнд гарын үсэг зурж гэрээ хүчин төгөлдөр болж зөвлөх үйчилгээ эхэлсэнээс хойш 42 хоногт буюу 1 сар 12 хоногийн дотор
2	Явцын тайлан	Гэрээнд гарын үсэг зурж гэрээ хүчин төгөлдөр болж зөвлөх үйчилгээ эхэлсэнээс хойш 84 хоногт буюу 2 сар 24 хоногт
3	Эцсийн тайлан	Гэрээнд гарын үсэг зурж гэрээ хүчин төгөлдөр болж зөвлөх үйчилгээ эхэлсэнээс хойш 180 хоног буюу 6 сар



Ажлын хуваарь

Ажлын талбайд хийх шинжилгээ, судалгаа

№	Хийгдэх ажил	Ажил эхэлсэн өдрөөс хойш 7 хоногтоор																									Тайлбар
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	
A: Бэлтгэл ажил																											
1	Холбогдох материал цуглуулах																										
2	Хайгуулын бэлтгэл ажил																										
B: Төлбөрийн судалгаа																											
1	Трассын судалгаа																										
2	Холбогдох байгууллагуудтай зөвшилцөх																										
3	Геодезийн хэмжээт судалгаа																										
4	Геологийн хайгуул судалгаа																										
C: ТЭЗҮ боловсруулалт, батлуулах ажил																											
1	Авто замын ТЭЗҮ тайлан боловсруулах ажил																										
2	ТЭЗҮ-г ШҮТЗ-ын хүрлээр оруулах																										
3	ТЭЗҮ батлуулах																										
4	Байгаль орчны төлөв байдлын судалгаа боловсруулах ажил																										
D: Авто замын зураг төсөл боловсруулах ажил																											
1	Авто замын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил																										
2	Инженер геодезийн тайлан гаргах																										
3	Инженер геологийн судалгаа тайлан гаргах																										
4	Хиймэл байгуулалчийн зураг төсөл боловсруулах ажил																										
5	Тайлбар бичиг боловсруулах																										
6	Төхнийн шаардлага боловсруулах																										
7	Ажлын тоо хэмжээ тооцох гаргах																										
8	Барилгын ажлын төсөв хийх																										
E: Зураг төсөлд "Магадлалын өрөнхий дүгнэлт" гаргуулах																											
1	Зураг төслийг улсын эксперт хийлгэх																										
2	Экспертийн саналыг зураг төсөлд тусгах																										
3	Ажлын зураг төслийг баталгаажуулах																										
F: Инженерийн нарийвчилсан зураг төслийг Засмалагчид хүлээлгэн өгөх, гэрээ дүгнэх																											
1	Засмалагч байгууллагад хүлээлгэн өгөх																										
G: Төвлөн																											
1	Эхлэлийн тайлан																										
2	Явцын тайлан тайлан																										
3	Эцсийн тайлан болон зураг төслийг хүлээлгэн өгөх																										


Хүндэтгэсэн,

Ажил гүйцэтгэх хугацаа: Гэрээ байгуулсанаас хойш 180 хоног

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, талий: 

Албан тушаал, нэр: Дэд захирал /Ж.БАТНАСАН /

Зөвлөх үйлчилгээний байгууллагын нэр: "ТЕО ЗУРАГЛАЛ" ХХК



Хавсралт №3 Ажиллах хүчин- Голлох мэргэжилтний ажлын хуваарь

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Овог, нэр	Албан тушаал	Сарууд /зөвлөх үйлчилгээ эхэлснээс хойш/						Бүгд хоног
			1	2	3	4	5	6	
1	Р.Болормаа	Авто замын инженер /зөвлөх инженер/							180
2	Ли Жон Хаг	Зургийн ерөнхий инженер /зөвлөх инженер/							180
3	Ж.Батнасан	Авто замын инженер /мэргэшсэн инженер/							180
4	Л.Сумхүү	Авто замын инженер /мэргэшсэн инженер/							180
5	М.Цас-Оргилмаа	Авто замын инженер /зөвлөх инженер/							180
6	Ш.Дугар	Геодезийн инженер /мэргэшсэн инженер/							180
7	Г.Очирдорж	Материалын инженер /мэргэшсэн инженер/							180
8	Б.Баатарцогт	Инженер геологич /мэргэшсэн инженер/							180
9	Г.Намуун	Инженер эдийн засагч /мэргэшсэн төсөвчин, мэргэшсэн инженер/							180
10	Ц.Цолмон	Мэргэшсэн төсөвчин /мэргэшсэн төсөвчин, мэргэшсэн инженер/							180

Үндсэн ажилтнаар: 10

Тайлангийн тоо: 3


Гүйцэтгэх хугацаа: 180 хоног (Энэ хугацаанд зураг төсөнд магадлал хийлгэх хугацаа ороогүй болно.)

Гарын үсэг:

Овог нэр:


Ж.БАТНАСАН
(Эрх бүхий этгээдийн)

"ГЕО ЗУРАГЛАЛ" ХХК-ийн захирал



Хавсралт №4 Төгрөгөөр тодорхойлсон төсөвт өртөг

№	Зардлын нэр	Үндэслэл	Нийт үнэ /төг/
1	Судалгааны ажил, тээвү		42,601,000
2	Зураг төсөл		182,973,527
3	Инженер геологийн судалгаа, тайлан		40,000,000
4	Геодезийн байр зүйн зураг, тайлан		65,000,000
5	ДҮН		330,574,527
6	НӨАТ-ын дүн		33,057,453
7	Экспертизийн зардал 6%		19,834,472
8	Захиалагчийн хяналтын зардал		6,611,491
9	Норм нормативын сангийн зардал		1,322,298
10	НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ		391,400,240



2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар:

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн баталгаа

Баталгаа хүлээн авагч: **БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**
УБ

Огноо: **2022-05-18**

Дугаар: **117DOC PF220446**

Баталгаа гаргагч: **Голомт банк ХХК**

1. ГЕОЗУРАГЛАЛ ХХК (цаашид "Үйлчилгээ үзүүлэгч" гэх) нь -г үзүүлэх зорилгоор БАРУУН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМААС МӨНХХАЙРХАН СУМ ЧИГЛЭЛИЙН 65 КМ АВТО ЗАМЫН ТЭЗҮ ЗУРАГ ТӨСӨЛ / ХОВД/ БХБЯ/202202198 (цаашид "гэрээ" гэх)-г Баталгаа хүлээн авагчтай байгуулсан тухай мэдээллийг ирүүлээд байна.
2. Үйлчилгээ үзүүлэгчийн хүсэлтээр Баталгаа гаргагч нь Баталгаа хүлээн авагчийн өмнө нийт 19570012.00 MNT-ийн төлбөрийн үүрэг хүлээж 19570012.00 MNT (Арван есөн сая таван зуун далан мянга арван хоёр төгрөг)-ийн баталгаа гаргаж байна.
3. Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Баталгаа гаргагч нь төлбөрийг тус мэдэгдэлд заасан дансанд үл маргах журмаар шилжүүлнэ.
4. Баталгаа гаргагчаас төлүүлэх шаардлагын хэмжээ нь энэ баталгааны 2-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба энэ хүрээнд захиалагчийн шаардсан аливаа мөнгөн дүнд ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.
5. Энэхүү баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчин төгөлдөр байна.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

Баталгаа гаргасан,

Банкны эрх бүхий албан тушаалтны нэр: **Д.БАЯШТУУЛ**

Албан тушаалын нэр: **ҮААМенежер**

Албан тушаалтны гарын үсэг:

Байгууллагын тамга, тэмдэг

Огноо: 2022-05-18

Хаяг: Голомт банкны төв байр, Д.Сүхбаатарын талбай 5, Ш/х-22, Улаанбаатар 15160, Монгол улс

